

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2024.12.10

Эрдэнэбулган

Шийдвэр д/д	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчин гүй болсон, хяналтаас хасуулах тухай санаал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
Монгол улсын хууль					
1	1.1	<p style="text-align: center;">Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2011-02-02 Дугаар 2011.02.02</p> <p>19.1.8. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх</p>	<p>2024 онд байгууллага бүтэц орон тооны хувьд бэхжиж, 8 орон тоотой ажиллалаа. Ажиллагсдын хүйсийн тэнцвэр эм-7, эр-1. Ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг аймгийн Засаг даргад 2025 оны 1 дүгээр сард хүргүүлнэ.</p>	100%	
2	2.1	<p style="text-align: center;">Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01</p> <p>55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	<p>“Архангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-т түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5 чиглэлээр 22 ажил арга хэмжээг 2015-2025 он хүртэл 2 үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр хамт олны хурлаар хэлэлцэн баталж, албаны жил, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт тусгагдсан нийт 8 арга хэмжээг 2024 онд төлөвлөн бүрэн хэрэгжүүлж, нийт 107.1 сая төгрөгийн төсөв зарцуулсан.</p>	100%	
3	3.1	<p style="text-align: center;">Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01</p> <p>8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;</p>	<p>Албаны эрхэм зорилго, зорилтууд, хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд албан үүргээ гүйцэтгэж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага бүрт төрийн үйлчилгээг цаг тухай бүрт хүргэх, ирүүлсэн өргөдөл хүсэлтийг богино хугацаанд шийдвэрлэх, анхаарал татсан асуудлаар 21 зөвлөмж бэлтгэн бусад байгууллага, төрийн албан хаагч нарт хүргэх ажлыг зохион байгуулж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөх, туслах арга хэмжээг авч ажилласан. Үүний үр дүнд аймгийн төрийн албан хаагчид, ард иргэд цалин хөлс, нэмэгдлийн тогтоолт, олголт, ээлжийн амралтын олговор, хугацаа тооцох аргачлал, тэтгэмжийн асуудлаар манай албанд хандаж, жирийн төрийн албан хаагч, иргэдийн санал хүсэлтийг түргэн шуурхай хүлээн авч үндэслэлтэй шийдвэрлэж чаддаг гол байгууллага гэсэн үнэлэлт дүгнэлтэд хүрч чадсан.</p>	100%	
	3.2	<p>8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг</p>	<p>Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба page хуудас, Мэдээллийн самбар, cd.ag.gov.mn вебсайтад албаны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх хаяг зэргийг байршуулснаар иргэд, олон нийт санал хүсэлтээ илэрхийлж, зөвлөгөө авч байна.</p>	100%	
	3.3	<p>8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;</p>	<p>Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө, Архангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сангийн яамны нэгдсэн арга зүй, салбарын болон аймгийн бодлого зорилтын хүрээнд боловсруулсан аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аудит, хяналт шалгалтыг төлөвлөгөөт 46, төлөвлөгөөт бус 7, нийт 53 байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулсны зэрэгцээ цаашид анхаарах асуудлаар зөвлөмж бэлтгэн</p>	100%	

		харилцагч байгууллагын төсөв захирагч нарт хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллалаа. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар 1,189.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, улсын байцаагчийн 67 актаар 625.2 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, тайлант хугацаанд 441.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулсан. Хугацаа болоогүй нөхөн төлбөр 117.4 сая төгрөг байна. Улсын байцаагчийн 41 албан шаардлагаар 564.2 сая төгрөгийн зөрчлийн арилгуулах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулан ажиллаж байна. 2024 онд албанаас төлөвлөсөн аудит, хяналт шалгалтыг бүрэн хийж, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгсөн бөгөөд аудитор, улсын байцаагч нар хяналт шалгалтын танилцуулга-18, дотоод аудитын тайлан-17, зөвлөмж 21-ийг үйлдсэн байна.		
3.4	8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Хуулийн тогтоомжийн хэрэгжилтийн тайланг албаны вебсайтад байршуулсан.	100%	
3.5	8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг албаны вебсайтад байршуулсан.	100%	
3.6	8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны ерөнхий хуулиуд, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт болон Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрэм, Сангийн сайдын 2016 оны Санхүүгийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж ажилладаг бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг албаны вебсайтад байршуулсан.	100%	
3.7	8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Албаны нийт ажилтан албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг нэгтгэсэн судалгаа гаргаж, албаны вебсайтад байршуулсан.	100%	
3.8	8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал тутам гаргаж, албаны вебсайтад байршуулсан.	100%	
3.9	8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Аудит, хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт болон үйл ажиллагааны статистик мэдээллийг албаны вебсайтад байршуулсан.	100%	
3.10	8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Хамааралгүй		
3.11	8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	2024 онд албанд төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо 1 гарсаныг Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлд мэдээлсэн.	100%	
3.12	8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Албанд ажилтан, албан хаагчийг сонгон шалгаруулж авахдаа Төрийн албаны тухай хууль, холбогдох журмыг баримталж ажилласан.	100%	
3.13	8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, мэргэжлийн ёс зүйн дүрмийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	100%	
3.14	8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Хүний нөөцийн стратегид аудитын менежер, нягтлан бодогч, хуулийн зөвлөх зайлшгүй байхаар төлөвлөсөн. Аймгийн Засаг даргын 2023 оны А/149 дүгээр захирамжаар баталсан албаны шинэчилсэн бүтэц, орон тоог шинэчлэн батлуулсан.	100%	
3.15	8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Батлагдсан орон тооны шийдвэр болон гүйцэтгэлээр ажиллаж байгаа орон тооны талаарх мэдээллийг албаны вебсайтад байршуулан мэдээлсэн.	100%	
3.16	8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	"Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын хүрээнд албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, тодорхой болгох чиглэлээр удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, аудит, хяналт шалгалтын ажлын явц байдлын талаар байгууллагын мэдээллийн самбарт мэдээлсэн.	100%	
3.17	8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Албаны 2023 оны төсвийн гүйцэтгэл, 2024 оны батлагдсан төсөв, гүйцэтгэлийг шилэн дансны цахим сайтад сар бүр байршуулсан. Албаны 2025 оны төсвийн төслийг бэлтгэн хуулийн хугацаанд хүргүүлсэн.	100%	
3.18	8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг байгууллагын Мэдээллийн самбарт байршуулж, эхний хагас жилийн санхүүгийн үзүүлэлтийн мэдээг Шилэн дансны нэгдсэн цахим сайтад байршуулсан. Албаны 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хүргүүлсэн бөгөөд одоогийн	100%	

			байдлаар жилийн эцсийн тайланг бэлтгэж байна.		
3.19	8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;		Албаны 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын санал дүгнэлт авсан. Жил жилийн санхүүгийн тайланг ил тод байршуулж хэвшүүлсэн.	100%	
3.20	8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;		Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс авдаггүй.	100%	
3.21	8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;		Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг Шилэн дансны нэгдсэн сайтад байршуулсан.	100%	
3.22	8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;		Албанаас 2024 онд таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалт болох "Пи Си Техно" ХХК-иас 18.1 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан.	100%	
3.23	8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;		Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого болох санхүүжилтийн орлогыг сар бүр байршуулсан.	100%	
3.24	8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;		Хамааралгүй		
3.25	8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;		Албанаас www.shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр мэдээллээ байршуулан, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласан. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, байршуулах ёстой мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулснаар мэдээлэл байршуулалт, тайлан илгээлт 100%-тай гарлаа. Аудитын байгууллагаас зөвлөмж чиглэл ирээгүй.	100%	
3.26	8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;		2024 онд албанаас орон нутгийн өмчийн хөрөнгөөр 18.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 5.5 сая төгрөгийн тавилгыг харьцуулалтын аргаар бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт хийсэн.	100%	
3.27	8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;		2022-2023 онд худалдан авалт хийгдээгүй.	100%	
3.28	8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;		Аудит, хяналт шалгалтаар хамрагдсан байгууллагын холбогдох ажилтанд худалдан авах ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	100%	
3.29	8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;		Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар төсөл хөтөлбөр хэрэгжээгүй.	100%	
3.30	8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;			100%	
3.31	8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)		Албаны төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгаж, ажилтан албан хаагчдад тогтмол мэдээлж хэвшсэн.	100%	
3.32	8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;		Хамааралгүй		
3.33	8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.		Хамааралгүй		
3.34	8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;		Хамааралгүй		

3.35	8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Хамааралгүй		
3.36	8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Хамааралгүй		
3.37	8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Эзэмшлийн газар байхгүй.	100%	
3.38	8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Хамааралгүй.		
3.39	8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	Хамааралгүй		
3.40	8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргасан тохиолдол гараагүй байна.	100%	
3.41	8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Хамааралгүй		
3.42	8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Хамааралгүй		
3.43	8.6.13. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Хамааралгүй		
3.44	8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Хамааралгүй		
3.45	8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Байгууллагаас сургалтын зардлыг хариуцан төлөхөөр хариуцагчтай гэрээ байгуулаагүй.	100%	
3.46	8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.)	Өөрийн эрхлэх асуудлын хүрээний мэдээллийг байгууллагын мэдээллийн самбар, вебсайтад байнга ил тод, нээлттэй байлгаж хэвшүүлсэн.	100%	

Хэсгийн дундаж 100 хувь

Засгийн газрын тогтоол

4	4.1	Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай	Албанаас байгууллагын тамга, нэр хаягийг үндэсний бичгээр стандартын	100%	
---	-----	---	--	------	--

		2013-02-02 Дугаар 05_2013_37 4. Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартыг бүх шатанд мөрдлөг болгож төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	дагуу хийлгэж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган Монгол хэлний бодлогын зөвлөлийн багш нараас үндэсний бичгийн 20 цагийн сургалтыг авч бүх ажилтан албан хаагчид хамрагдаж, Батламжаа гардан авсан..		
5	5.1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25. Дугаар 2022_203 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;	1.1 Хамааралгүй 1.2 Албаны 2025 оны төсвийн төслийг хууль тогтоомж, тогтоол шийдвэрт нийцүүлэн боловсруулж, аймгийн Засаг даргад 2024 оны 07 сарын 8-ны 103 тоот албан бичгээр хүргүүлсэн. 1.3 Төсвийн захирагч, санхүү бүртгэлийн ажилтны аймгийн зөвлөгөөн, Соёл урлагийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн болон дотоод сургалтыг танхимаар, бусад сургалт, зөвлөгөө мэдээллийг цахимаар зохион байгуулсан.	100%	
	6.1	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25. Дугаар 2022_204 Автомашин хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Архангай аймгийн ИТХ-ын 2024 оны 04 сарын 29-ний өдрийн 10 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын хэрэгцээнд ашиглагдаж байсан пургон машин албанд шилжиж ирсэн. Орон нутагт хийгдэх дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын ажилд ашиглаж байна.	100%	
6	6.2	Энэ тогтоолын 1-д заасны дагуу татан төвлөрүүлсэн төрийн өмчид бүртгэлтэй суудлын автомашиныг “Засгийн газрын автобааз” УТҮГ-т, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашиныг тухайн аймаг, нийслэлийн харьяа автотээврийн байгууллагад шилжүүлж, төрийн болон орон нутгийн байгууллагын нийтлэг үйлчилгээний хүрээнд дуудлагын автомашины зориулалтаар ашиглуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай	Хамааралгүй		
	6.3	Дуудлагын автомашины зориулалтаар хуваарилан шилжүүлснээс бусад автомашиныг төрийн холбогдох байгууллагын зайлшгүй шаардлага, хэрэгцээг харгалзан эрэмбэлсний үндсэн дээр зарим хэсгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан байгууллагад албан ажлын зориулалтаар хуваарилах, үлдэх хэсгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	Хамааралгүй		

		(Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.				
	6.4	Автомашин хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. .	Хамааралгүй			
7	7.1	<p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05. Дугаар 2022_7</p> <p>5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасгай:</p> <p>5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;</p> <p>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;</p> <p>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;</p> <p>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;</p> <p>5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.</p>	<p>“Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг”-ийг кирилл, монгол бичгээр хэвлүүлж, албан өрөөнд байршуулсан.</p> <p>Төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолд заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших зорилгоор албаны хэвлэмэл хуудсыг үндэсний бичигт хөрвүүлж, хянуулахаар аймгийн Архивын тасагт хүргүүлсэн.</p> <p>Албаны албан хаагчид үндэсний бичгээ сэргээж, бие даан суралцаж байна. Мөн сургалтын төлөвлөгөөний дагуу Үндэсний бичгийн 20 цагийн мэргэжлийн багшийн сургалтыг авч мэдлэг чадвараа дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p> <p>Албаны гадна болон өрөө тасалгааны хаягийг үндэсний бичгээр бичүүлж шинэчлэн байршуулсан. “Төрийн албан хаагчийн нэрийн хуудсанд тавих ерөнхий шаардлага” стандартыг албан хаагчдад танилцуулсан.</p>	100%	100%	95%
<i>Хэсгийн дундаж 98.3 хувь</i>						
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ						
8	8.1	<p>2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11</p> <p>“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.</p>	Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инноваци нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлэн бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг ханган ажиллах талаар анхаарч ажиллалаа. Цахим шилжилтийг үе шаттай хийх, цахим засаглалд шилжих үйл явцад идэвх, санаачилга гарган албаны цахим хуудсанд иргэдийн өргөдөл хүсэлт, санал гомдлыг цахимаар хүлээн авах боломжийг бүрдүүлснээр иргэд, байгууллагаас ирүүлсэн 55 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг эхнээс нь зөв хэрэглэх, танилцуулах ажлууд хийгдлээ.	100%		

9	9.1	<p>2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28</p> <p>Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.</p>	<p>Ажилтан албан хаагчид тоон гарын үсгээ авсанаас гадна албаны зарим үйл ажиллагаанд тоон гарын үсгийг нэвтрүүлж ажилласан.</p>	100%	
---	-----	---	--	------	--